



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн зурагт анхааруулга батлах
тухай

Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн 6.4-6.7, 9.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Тамхины хайрцаг, сав, баглаа боодол дээр хэвлэх, тамхины хэрэглээнээс хүний эрүүл мэндэд учрах хор хөнөөлийг харуулсан тайлбар бүхий эрүүл мэндийн зурагт анхааруулга, тайлбарын хамт нэгдүгээр, эрүүл мэндийн зурагт анхааруулга, түүний тайлбарт тавигдах шаардлагыг хоёрдугаар, тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдгийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн зурагт анхааруулгыг тамхин бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагад тусгах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (С.Эвлэгсүрэн)-т, эрүүл мэндийн зурагт болон тамхи татахыг хориглосон анхааруулгыг сурталчилах, хэвлүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх асуудлыг зохицуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Д.Дамдиндорж)-т тус тус үүрэг болгосугай.

3. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2006 оны 368 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

001647

26
Эрүүл мэндийн сайдын 2013
оны 02 дүгээр сарын 04-ний
өдрийн 36 тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГА, ТҮҮНИЙ ТАЙЛБАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа боодол дээр “Эрүүл мэндийн зурагт анхааруулга”, түүнийг тайлбарласан бичмэл тайлбарыг хэвлэсэн байна.

2. Эрүүл мэндийн зурагт анхааруулгын зураг, түүнийг тайлбарласан тайлбар агуулгын хувьд тохирсон байна.

3. Эрүүл мэндийн зурагт анхааруулгын тайлбарын хэсэг нь тус зурагт анхааруулгын эзлэх талбайн хэмжээнд багтахгүйгээр тусдаа байрлана.

4. “Эрүүл мэндийн зурагт анхааруулга”-д тавигдах шаардлага:

4.1. Эрүүл мэндийн зурагт анхааруулга нь тамхинаас хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг харуулсан энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан зургаан зураг байна.

4.2. Янжуур тамхины хайрцаг бүрийн нүүр болон ар талын талбайн хэсэг тус бүрийн дунд хэсгийн 50 хувьд эрүүл мэндийн зурагт анхааруулга нь байна.

4.3. Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины сав, баглаа боодол бүрийн нүүрэн талын гадаргууны талбайн дунд хэсгийн 50-аас багагүй хувийг эрүүл мэндийн зурагт анхааруулга эзэлсэн байна.

4.4. Зурагт анхааруулга нь эх хувьтайгаа адилхан, тусгал сайтай, тод харагдахуйц, 4 өнгөтэй байна.

4.5. Зурагт анхааруулга нь нэг мм өргөнтэй хар өнгийн хүрээтэй байна.

4.6. Зурагт анхааруулгын талбайд ямар нэгэн нэмэлт зураг, бичиглэл хийхгүй.

5. Эрүүл мэндийн зурагт анхааруулгын “тайлбар”-т тавигдах шаардлага:

5.1. Эрүүл мэндийн зурагт анхааруулгын тайлбарын талбайн хэмжээ уртаараа 5см, өргөнөөрөө 2см буюу 10см.квadrатаас доошгүй талбайг эзэлсэн байна.

5.2. Тайлбарын эзлэх талбайн суурь өнгө улаан, бичиглэл нь цагаан өнгөтэй, тодоор бичигдсэн байна.

5.3. Тайлбар бичиглэлийг компьютерийн “Arial”-фондын “12” хэмжээтэй, “bold”, том үсгийн хэмжээгээр бичсэн байна.

5.4. Янжуур тамхины хайрцаган дээрх байрлах эрүүл мэндийн зурагт анхааруулгатай зэрэгцүүлэн дор хэсэгт нь зурагт анхааруулгын тайлбарыг байрлуулна.

27

5.5. Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины сав, баглаа боодол дахь эрүүл мэндийн зурагт анхааруулгын тайлбарыг түүний дор байрлуулна.

5.6. Зурагт анхааруулгын тайлбар 6 төрөлтэй байна.

5.6.1. Тамхи татсанаар нүүр харлан үрчлээ ихэсч эрт хөгширнө.

5.6.2. Тамхи уруул, амны хөндийн эрхтний хорт хавдар үүсгэнэ.

5.6.3. Тамхи бэлгийн сулрал үүсгэнэ.

5.6.4. Тамхи судасны бөглөрөл үүсгэн захын эрхтэн тайрагдахад хүргэнэ.

5.6.5. Тамхинд үхэлд хүргэх 4000 гаруй химийн хорт бодис агуулагддаг.

5.6.6. Тамхи ургийн гаж хөгжил үүсгэнэ.

-oOo-

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
02 дүгээр сарын 04 ний өдрийн 36
тоот тушаалын гуравдугаар
хавсралт

**ТАМХИ ТАТАХЫГ ХОРИГЛОСОН АНХААРУУЛАХ
ТЭМДГИЙН ЗАГВАР**

Загвар

“...Тухайн байгууллагын нэр...” – Тамхигүй орчин



УТААТ ТАМХИ ТАТАХЫГ ХОРИГЛОНО.

Тамхины хяналтын тухай хуулийн 9.1 дэх заалтыг зөрчсөн
...иргэнийг **50000** төгрөг, албан тушаалтныг 1 сарын хөдөлмөрийн
хөлсний доод хэмжээг **10-25** дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх
хэмжээний төгрөгөөр... торгоно.”

Мэдээлэл хүлээн авах хэсэг:

Байгууллагын хаяг:.....

Албан тушаалтны нэр:.....

Утасны дугаар:.....

Хэрвээ Та тамхинаас гарахыг хүсвэл утсанд залгаж
зөвлөгөө авна уу.


Жич: Зөвлөгөө өгөх утасны дугаарыг тухайн байгууллага сонгон ажиллуулна.

29
Эрүүл мэндийн сайдын 2013
оны 02 дүгээр сарын 04-ний
өдрийн 36 тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГА, ТҮҮНИЙ ТАЙЛБАР

Зурагт анхууруулга №1

ТАМХИ ТАТСАНААР НҮҮР ХАРЛАН,
ҮРЧЛЭЭ ИХЭСЧ, ЭРТ ХӨГШИРНӨ.



Зурагт анхууруулга №2

ТАМХИ УРУУЛ, АМНЫ ХӨНДИЙН
ЭРХТНИЙ ХОРТ ХАВДАР ҮҮСГЭНЭ.



нэгдүгээр хавсралтыг 2013 оны
146-р тушаалаар хүчингүй
болгов.

Зурагт анхууруулга № 3

ТАМХИ БЭЛГИЙН СУЛРАЛ ҮҮСГЭНЭ.




Зурагт анхааруулга №4

ТАМХИ СУДАСНЫ БӨГЛӨРӨЛ ҮҮСГЭН ЗАХЫН
ЭРХТЭН ТАЙРАГДАХАД ХҮРГЭНЭ



Зурагт анхааруулга №5

ТАМХИНД ҮХЭЛД ХҮРГЭХ 4000 ГАРУЙ
ХИМИЙН ХОРТ БОДИС АГУУЛАГДДАГ.



Зурагт анхааруулга № 6

ТАМХИ УРГИЙН ГАЖ ХӨГЖИЛ ҮҮСГЭНЭ.

